



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/58/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг:

tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг:

erdenechimegd@audit.gov.mn

Аудитор Н.Гэрэлмаа

Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-12
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
ГАЗРЫН ДАРГА
Ж.АМГАЛАНБААТАР ТАНАА

2023.02.18 № 18

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын онцолсон хэсэг

Аймгийн Боловсролын газрыг 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн Засгийн газрын тогтоолоор Боловсрол, шинжлэх ухааны газар болгон өөрчилснөөр бүтэц орон тоо нэмэгдэн 24 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргасан албан байгууллага, захирал, сургалтын менежер, багш сурагчдыг шагнаж урамшуулахад нийт 365.1 сая төгрөг, улс бүсийн чанартай уралдаан тэмцээн зохион байгуулах болон элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт үзүүлсэн багшийг урамшуулах зардалд 16.0 сая төгрөг, Засаг даргын нэрэмжит олимпиад тэмцээн зохион байгуулах зардалд 20.0 сая төгрөг, хос бичигтэн арга хэмжээний зардалд 18.9 сая төгрөгийг захирамжийн дагуу тус тус зарцуулсан байна.

Тайлант онд НҮБ-ын хүүхдийн сангаас 290.4 сая төгрөгийн санхүүжилт авч төслийн шаардлагын дагуу чадавхжуулах сургалт болон тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэхэд зарцуулсан.

0702000046

Аудитын гол асуудал

Боловсролын салбарт тайлант онд хийгдсэн томоохон өөрчлөлт нь гүйцэтгэлд суурилсан төсвийн шинэчлэл хийгдэж байгаа явдал юм. 2022 оны гүйцэтгэлийн үнэлгээгээр аймгийн хэмжээнд 28 сургуулиас 18 сургууль, 31 цэцэрлэгээс 16 цэцэрлэг гүйцэтгэлийн үнэлгээний босго оноо давж 1-4-р түвшинд үнэлэгдэн урамшуулал авсан бол аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар гүйцэтгэлийн үнэлгээгээр улсад 1-р байрт шалгарсан байна.

Байгууллага нь тайлант онд 19 зорилтын хүрээнд 96 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 97.4 хувьтай дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(мянган төгрөг)

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	106,207.52	61,402.67
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	862,516.25	1,151,418.70
	Нийт хөрөнгийн дүн	968,723.77	1,212,821.37
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	968,723.77	1,212,821.37
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	968,723.77	1,212,821.37
Үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,534,367.45	4,368,049.16
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,723,344.97	4,123,951.56
	Үйл ажиллагааны үр дүн	811,022.48	244,097.60
	Үйл ажиллагааны бус үр дүн	(25,666.67)	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	785,355.81	244,097.60
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	968,723.77	968,723.77
	Тайлант оны үр дүн	-	244,097.60
	Эцсийн үлдэгдэл	968,723.77	1,212,821.37
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,723,695.28	3,898,974.55
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,695,749.38	3,888,124.55
	Үйл ажиллагааны ЦМГ	27,945.90	10,850.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,050,399.31	2,891,864.11
	Урсгал зардал	2,050,399.31	2,891,864.11
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,050,399.31	2,891,864.11
	Улсын төсвөөс санхүүжих	2,050,399.31	2,891,864.11
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	-
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 5.6 сая төгрөгийн алдаа¹, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг зөрчсөн 5.6 сая төгрөгийн гүйлгээг аудитын явцад гүйлгээг нөхөн шивүүлж, зөрчлийг арилгасан.

Үүнд:

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

- ✓ **Хууль тогтоомжтой холбоотой:** Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 5.6 сая төгрөгийн гүйлгээг системд нөхөн шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 17.2 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 4.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 заалт албан шаардлага, 2 заалт зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин дотор 1.0 сая төгрөгийн шатахууныг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно", 6.2-т "Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно" заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Ажиллагсдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 0.6 сая төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин байгууллагын ажилчдын дунд тэмцээн зохион байгуулж 0.5 сая төгрөгийн шагнал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Батлагдсан бүтэц, орон тооноос илүү жижүүр томилон ажиллуулж 2.1 сая төгрөгийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;" 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Монгол улсын боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/125 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны 05 сарын А/273 дугаар захирамж" заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

- ✓ Бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг өмнөх оны зарцуулалттай харьцуулж үзэхэд 1.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;" 15.2.4-т "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх" заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Харилцагч байгууллагатай тооцоо нийлээгүй нийгмийн даатгалын хэлтэст 9.7 сая төгрөг, татварын байгууллагад 3.3 сая төгрөгийг илүү шилжүүлж 13.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн, оршин байх, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 6 дугаар зүйл "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автомашинд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар олгох арга хэмжээг 2022 онд багтаан зохион байгуулах, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 1-т "Автомашин хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, төрийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлж, тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасгай"-ийн дагуу авто тээврийн хэрэгслийг тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугааргүй, автомашиныг парклагүй байна.

Өгсөн зөвлөмж:


- ✓ Байгууллагын эзэмшиж ашиглаж байгаа авто тээврийн хэрэгслийг тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугаартай болгох, автомашиныг парклуулах ажлыг зохион байгуулах

2. Шилэн дансны тухай хуультай холбоотой

- ✓ Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 720.1 сая төгрөгийн 73 мэдээллээс, 209.5 сая төгрөгийн 9 мэдээллийг мэдээлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

- ✓ Дутуу мэдээлсэн мэдээллийг шилэн дансанд мэдээлэх.



Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 12 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Боловсрол шинжлэх ухааны газар	1	5.6	-	-	1	5.6	1	5.6	-	-	-	-
Дүн	1	5.6	-	-	1	5.6	1	5.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл


/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Боловсрол шинжлэх ухааны газар	6	17.2	4	4.2	2	13.0	-	-	-	-	-	-
Дүн	6	17.2	4	4.2	2	13.0	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Боловсрол шинжлэх ухааны газар	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Боловсрол шинжлэх ухааны газар	1	-			-	-	1	-
Дүн	1	-			-	-	1	-
Нийт дүн	2	-			-	-	2	-



Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	-	1	-	-	1	-	-	-
	НИЙТ		1			1			